



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/416

Чойбалсан

ГҮХРИЙН АРСЬ ТОВРУУТАХ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ЯАРАЛТАЙ ДАРХЛААЖУУЛАЛТЫН
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, "Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.8, аймгийн Эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5.7.1, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/240 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын арга хэмжээг Дорнод, аймгийн эрсдэл бүхий Булган, Хөлөнбуйр, Хэрлэн сумдын нутаг дэвсгэрт байгаа мэдрэмтгий үхэр сүрэгт 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд зааврын дагуу шуурхай зохион байгуулж, дүн мэдээг аймгийн Мал эмнэлгийн газарт мэдээлж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

2. Дархлаажуулалтын ажлыг дуусах хүртэлх хугацаанд дээрх сумдаас амьд үхэр, тэдгээрийн гаралттай түүхий эд, мал, маханд гэрчилгээ олгох ажлыг түр зогсоохыг аймгийн Мал эмнэлгийн газар (Ч.Аюушмаа)-т чиглэл болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулж, малын хашаа, хороо, ажиллах хүн хүчээр хангаж ажиллахыг нийт малчид, мал бүхий иргэдэд уриалсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Ганбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ЁЛ